


БАТЛАВ: ДИСПЕТЧЕРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ  
ТӨХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Г.БАЛЖИННЯМ/

БАТЛАВ: МОНГОЛЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ  
БАРИЛГА ЗАСВАРЧДЫН ХОЛБОО ТББ  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/Д.ГАНБААТАР/

## СУРГАХ, СУРГАЛТАНД ХАМРАГДАХ ГЭРЭЭ

2022 оны 08-р сарын 12-ны өдөр

№78/2022

Улаанбаатар хот

Нэг талаас Диспетчерийн Үндэсний Төв /ДҮТ/ ТӨХХК /цаашид “Захиалагч” гэх/, түүнийг төлөөлж Техник хяналтын албаны дарга ажилтай Ц.Батмагнай, нөгөө талаас Монголын эрчим хүчний барилга засварчдын холбоо ТББ /цаашид “Сургагч” гэх/, түүнийг төлөөлж Гүйцэтгэх захирал ажилтай Д.Ганбаатар /хамтад нь “Талууд” гэх/ нар Монгол Улсын Иргэний хууль, холбогдох хууль тогтоомж, ДҮТ ТӨХХК-ний сургалтын төлөвлөгөө, Захиалагчийн тавьсан шаардлага, удирдамжийн дагуу сургалтанд сургахаар Талууд дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэ ГЭРЭЭГ байгуулав.

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү гэрээгээр Захиалагчийн хавсралтад заасан ажилтнуудад хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн чиглэлээр мэдлэг, чадамж эзэмшүүлэх сургалт хийх
- 1.2. Талууд хамтран баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу сургалт явуулна. Сургалтын хөтөлбөр нь энэ гэрээний салшгүй нэг хэсэг байна.

### ХОЁР. СУРГАЛТЫН ТӨЛБӨР БА ХУГАЦАА

- 2.1. Сургалт явуулах хугацаа, эхлэх, дуусах товыг талууд харилцан тохиролцож, сургалтын хөтөлбөрт тусгах ба төлөвлөгөөг гэрээнд заавал хавсаргана.
- 2.2. Сургалтын нийт төлбөр нь 15,750,000.00 /арван таван сая долоон зуун тавин мянга/ төгрөг байна. Энэхүү төлбөрт НӨАТ орсон болно.
- 2.3. Сургалтын хөтөлбөрт тусгасан сургалтын төлбөрийг сургагчаас ирсэн санхүүгийн баримтыг үндэслэн ажлын 7 хоногийн дотор сургагчийн харилцах банкны дансанд шилжүүлнэ.

### ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Талууд батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалтын материалыг бэлтгэж хуваарийн дагуу сургалтыг чанартай гүйцэтгэнэ.
- 3.2. Сургалтад хамрагдагчдаас санал асуулга авах замаар сургалтын үйл ажиллагаа, чанарт хяналт тавина.
- 3.3. Сургалтын үйл ажиллагаа, зохион байгуулалтын талаар санал гаргаж, шаардлага тавина.
- 3.4. Сургалтын байгууллага сургалтын тайланг суралцагчийн өргөдөлд хавсаргасан баримт бичиг, эрх олгох шалгалтад хамруулах хүсэлтийн хамт ирүүлсэнээс хойш ажлын 7 хоногт багтаан сургалтын байгууллагатай хамтран шалгалт авах ажлыг зохион байгуулна.
- 3.5. Сургалттай холбоотой төлбөрийг сургалтын хөтөлбөрт тусгасны дагуу гэрээнд заасан хугацаанд төлөх;
- 3.6. Сургалтанд хамрагдах суралцагчдын мэдээллийг гаргаж өгөх, тэдгээрийг сургалтад бүрэн хамрагдах боломж нөхцөлөөр хангах,
- 3.7. Суралцагчдийн буруутай үйлдэл, үйл ажиллагаанаас хамааран гэрээнд заасан хугацаанд сургалтанд бүрэн хамрагдаж чадаагүйтэй холбоотой асуудлыг бие даан хариуцах;

- 3.8. Сургагч нь сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу чанартай явуулахад сургалтын материал, гарын авлага, сургалтад шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, анги танхимаар суралцагчдыг сургалтын төлбөрт багтаан хангана.
- 3.9. Сургагч нь сургалтын явцад суралцагчдын ирц, идэвх зэрэг оролцоонд, сургагч багш нарт хяналт тавина.
- 3.10. Гэрээтэй холбоотой талууд олж мэдсэн бүхий л мэдээллийг аливаа хэлбэрээр гуравдагч этгээдэд задруулахгүй байх үүрэгтэй.
- 3.11. Сургагч нь сургалтын төлбөрийг гэрээнд заасны дагуу хугацаанд нь нэхэмжлэн авах.

#### **ДӨРӨВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА ДУУСГАВАР БОЛОХ БА ЦУЦЛАХ**

- 4.1. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээний талаар маргаан гарах, гэрээний хугацааг сунгах болон цуцлах асуудлыг хоёр тал бичгээр санал солилцох замаар шийдвэрлэнэ.
- 4.2. Аль нэг тал энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа зөрчсөн тохиолдолд гэрээг нэг талын санаачилгаар хугацаанаас өмнө цуцалж болох бөгөөд энэ тухай нөгөө талдаа албан бичгээр мэдэгдэнэ.
- 4.3. Сургалт явуулах гэрээг зөрчсөн сургалтын байгууллагын гэрээг хүчингүй болгож, дараагийн нэг жилийн хугацаанд тус сургалтын байгууллагатай гэрээ байгуулахгүй.
- 4.4. Гэрээнд заасан хугацаа дуусмагц гэрээг хүчингүй болсонд тооцно.

#### **ТАВ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ**

- 5.1. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг Талууд зөвшилцэх замаар шийдвэрлэнэ.
- 5.2. Хэрэв гэрээний 5.1-д заасан замаар маргааныг шийдвэрлэж чадахгүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### **ЗУРГАА. БУСАД**

- 6.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 6.2. Энэхүү гэрээг 3 хувь үйлдэж Захиалагч 1 хувь, Сургагч 2 хувийг хадгалсан нь хууль зүйн хувьд адил хүчинтэй.

#### **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

ЗУА-НЫ ДАРГА

/Б.БИНДЭРЬЯА/

СЭЗА-НЫ ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ НЯГТЛАН  
БОДОГЧ

/Т.БЯМБАЖАВ/

ТХА-НЫ ДАРГА

/Ц.БАТМАГНАЙ/

ХУУЛЬЧ

/Б.АНХЗАЯА/

**СУРГАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

ЗАХИРАЛ

/Д.ГАНБААТАР/

СХА-НЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  
/Д.БОЛОРМАА/

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  
/С.НАМЧИНДОРЖ/

ХАЯГ:

Монгол Улс, Улаанбаатар хот 17060 Хан-уул  
дүүрэг, 3-р хороо, Чингисийн Өргөн чөлөө  
Засгийн газрын XIV байр 4,5 давхар  
Утас: 7004 1371  
Факс: 70043467

ХАЯГ:

Банк: Хаан банк  
Данс: 5131490329